МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР

САНГИЙН ЯАМ

ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
УДИРДЛАГЫН ЦАХИМ СИСТЕМ

# ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН УДИРДЛАГА БА ТӨР, ХУВИЙН ХЭВШЛИЙН ТҮНШЛЭЛ

*Сангийн яам, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга **Ж.ДЭЛГЭРЖАРГАЛ***

www.publicinvestment.gov.mn

# Агуулга

**ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН УДИРДЛАГА**

ТӨР, ХУВИЙН ХЭВШЛИЙН ТҮНШЛЭЛ

ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЯВЦАД ҮҮСЭЖ БУЙ АСУУДАЛ, ШИЙДЭЛ

# ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН АЧ ХОЛБОГДОЛ, ҮР ӨГӨӨЖ

- I Улсын төсөв
- II Гадаад зээл, тусламж
- III Орон нутгийн төсөв
- IV Концесс / ТХХТ
- V Орон нутгийн хөгжлийн сан
- VI Төрийн өмчит ААН
- VII Зарим сангууд

**ЭДИЙН ЗАСГИЙН ДЭД БҮТЭЦ**

- ✓ Эрчим хүч
- ✓ Авто зам
- ✓ Төмөр зам
- ✓ Усан хангамж
- ✓ Инженерийн шугам
- ✓ Цэвэршүүлэх байгууламж
- ✓ Холбоо дохиолол
- ✓ Логистик байгууламж
- ✓ Дулаан хангамж

**НИЙГМИЙН ДЭД БҮТЭЦ**

- ✓ Боловсролын салбар
- ✓ Эрүүл мэнд
- ✓ Нийгмийн хамгаалал
- ✓ Соёл, спорт
- ✓ Гадаад харилцаа
- ✓ Хууль зүй, батлан хамгаалах
- ✓ Технологи
- ✓ Дижитал мэдээллийн сүлжээ г.м

## ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЭДИЙН ЗАСГИЙН ҮР АШИГ БА ҮР НӨЛӨӨ:

- ✓ Эдийн засгийн өсөлтийг дэмжих
- ✓ Ажлын байр бий болгох
- ✓ Бүс нутгийн хөгжлийг дэмжих
- ✓ Технологийн дэвшлийг дэмжих
- ✓ Төсвийн орлогыг нэмэгдүүлэх

## ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН НИЙГМИЙН АЧ ХОЛБОГДОЛ:

- ✓ Дэд бүтцийн хөгжлийг бий болгох
- ✓ Боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх
- ✓ Соёл, урлагийн байгууллагыг дэмжих
- ✓ Батлан хамгаалах, гадаад харилцаа, хууль эрх зүй

# ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ 2016-2026




- ✓ *2016-2025 онд **50.3** их наяд төгрөгийн төсвийн хөрөнгө оруулалт батлагдсан.*
- ✓ *2026 онд **8.5** их наяд төгрөгийн төсвийн хөрөнгө оруулалт батлагдсан.*

# ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ШИНЭЧЛЭЛ



**2026**

- **Гадаад зээл, тусламж**
- **Зохиогчийн хяналт**
- **21 аймгийн төсөв**
- **Технологийн шинэчлэл**

**2025**

- **ЗГ-ын 108-р тогтоол**: нэмэлт өөрчлөлт
- **СС-ын 174-р тушаал :** Нэгдсэн нэгжийн үйл ажиллагаанд шилжүүлэх
- **Газарзүйн мэдээллийн дэд систем – www.map.publicinvestment.gov.mn**

**2024**

- **Нийслэлийн төсөв**
- **Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ**
- Вэб, апп дээр **олон эх үүсвэр нэмэгдэв**
- Захиалагчийн хяналт
- **Гадаад зээл, тусламж:** ТХН-ийн үйл ажиллагаа
- **ODAMIS – PIMIS:** Баазын түвшинд холболт хийж, ГЗТ эх үүсвэрийн бизнес шинжилгээ

**2023**

- **Улсын төсөв**
- УТХО-д иргэдээс **АНХ УДАА** санал авав
- Орон нутгийн төсөв
- ДБ-ны **8 элемент** нэвтрүүлэв
- **ЗГ-ын 278-р тогтоол**: "ТХО-аар хэрэгжүүлэх төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах" журам шинэчлэгдэв
- Вэб, апп шинэчлэл
- **СС-ын 137-р тушаал:** "Улсын хөрөнгө оруулалтын төслүүдийг хэрэгжүүлэх оновчтой эх үүсвэрийг тодорхойлох урьдчилсан үнэлгээний аргачлал"

**2022**

- **Төр, хувийн түншлэлийн тухай хуулийг батлуулав**
- **Вэб, апп шинэчлэл**
- ТХО-ын удирдлага, үр ашгийг сайжруулах зохицуулалтыг Төрийн хэмнэлтийн тухай хуульд тусгаж батлуулав.

**2021**

- **ЗГ-ын 160-р тогтоол:** "Хэрэгжилт, санхүүжилт, хяналтын тогтолцоог сайжруулсан, ил тод, олон нийтийн оролцоог бий болгох журам"

**2019**

- **Цахим систем нэвтрүүлэв**
- **Гар утасны апп**
- **СС-ын 295-р тушаал:** "Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг үнэлэх, эрэмбэлэх, сонгох журам"

# КОНЦЕСС → ТХХТ




## **25.5** их наяд төгрөгийн **60** төсөл

- “Барих – Шилжүүлэх” гэрээтэй 40 төслийн 2.2 их наяд ₮-ийн гэрээ байгуулсан, 1.6 их наяд ₮-ийн эргэн төлөлт хийгдсэн
- “Барих – Ашиглах - Шилжүүлэх” гэрээтэй 20 төсөл /23.3 их наяд ₮/

# КОНЦЕССЫН АСУУДЛУУД

**ҮАГ**

**Институтийн тогтворгүй байдал**
2010 оноос хойш концессын асуудал хариуцсан нэгж 7 байгууллага дамжсан.

**ҮАГ**

**Хууль зөрчсөн сонгон шалгаруулалт**
Концесс эзэмшигчийг сонгох аргыг тодорхойлох, шалгаруулалт явуулахдаа холбогдох хууль, журмыг зөрчсөн

**СЯ**

**Хуулийн шаардлага хангаагүй шууд гэрээ**
Нийт гэрээний 60% нь шууд гэрээ

**ҮАГ,СЯ**

**Хуулийн шаардлага хангаагүй төслийн жагсаалт**
Төслүүдийн үр ашиг, ач холбогдлыг тооцоогүй ЗГ-аар батлуулсан

**СЯ**

**Төсөвт ихээхэн ачаалал үүссэн**
Б-Ш төрлийн 37 төслийн нийт эргэн төлөлт 2 их наяд /2016-2025 он/

**ҮАГ**

**Хуульд заасан журам, аргачлал батлагдаагүй**
Концессын хуульд заасан холбогдох журам, аргачлалууд батлагдаагүй байх төслүүд хэрэгжсэн

**ҮАГ**

**Салбар яамдын оролцоогүй**
Сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, хэрэгжүүлэх, хяналт тавихад салбарын яамд оролцдоггүй

**СЯ**

**Төсөвт үзүүлэх нөлөө, эрсдэлийг тооцдоггүй**
Гэрээ байгуулах төслүүдийн төсөвт үзүүлэх нөлөө, эрсдэлийг тооцдоггүй, СЯ-ны оролцоо байхгүй

## ТӨР, ХУВИЙН ХЭВШЛИЙН ТҮНШЛЭЛИЙН ТУХАЙ

УИХ 2022.12.09-ний өдөр баталсан.

# БУСАД УЛС ОРОНД

| УЛС | МОНГОЛ УЛСТАЙ ИЖИЛ ТӨСТЭЙ ТАЛ | ЖИШЭЭ | ЭХ СУРВАЛЖ |
|---|---|---|---|
| **КАЗАКСТАН** | Байгалийн баялагт суурилсан эдийн засаг, төрийн оролцоо өндөр | Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төслүүдийг улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт нэгтгэн тусгаж, төсөвт зөвхөн төрөөс хүлээх төлбөрийн үүрэг, баталгааг бүртгэн, төсвийн эрсдэлийн хүрээнд тайлагнадаг | World Bank (2024) *Kazakhstan Public Finance Review* |
| **ВЬЕТНАМ** | Хурдацтай хөгжиж буй, дэд бүтцийн хэрэгцээ өндөр | Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төслүүдийг улсын хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгаж, төсөвт зөвхөн төрийн хамтын санхүүжилт (VGF)-ийг бүртгэн, дунд хугацааны төсвийн хүрээнд төлөвлөдөг | World Bank (2024) *PPP Reference Guide* |
| **ГҮРЖ** | Жижиг эдийн засаг, институцийн шинэчлэл | Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төслийг хэрэгжүүлэхээс өмнө Сангийн яамнаас төсөвт үзүүлэх нөлөөллийг үнэлж, зөвхөн төрийн санхүүгийн үүргийг бүртгэдэг | IMF (2025) *PPP Fiscal Risk Assessment* |
| **ТАЙЛАНД** | Дунд орлоготой, дэд бүтцийн томоохон хөрөнгө оруулалт шаарддаг | Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төслүүдийг үндэсний хөрөнгө оруулалтын төлөвлөгөө болон түншлэлийн төслүүдийн жагсаалтад нэгтгэн тусгаж, төсөвт зөвхөн төрөөс хүлээх төлбөрийн үүрэг, татаасыг бүртгэнэ. Дунд хугацааны төсвийн хүрээнд 5 жилээр төлөвлөж, төслийн төсөвт үзүүлэх нөлөөллийг Сангийн яам болон Төрийн өрийн удирдлагын байгууллага (PDMO) хамтран хянадаг | World Bank (2024); IMF (Thailand Article IV); Thailand PPP Act 2019 |
| **ЧИЛИ** | Түүхий эдийн экспорт давамгай | Төр, хувийн хэвшлийн түншлэлийн (концесс) төслүүдийг улсын хөрөнгө оруулалтын багцад нэгтгэн тусгаж, төсөвт зөвхөн баталгаа болон төрөөс хүлээх төлбөрийн үүргийг бүртгэн, төсвийн эрсдэлийн тайланд тусган тайлагнадаг | IMF (Chile, 2018); OECD (Chile, 2023) |

*Олон улсын туршлагаас (Перу, Чили, Тайланд, Казахстан зэрэг) харахад ТХХТ-ийн төслүүдийг төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтөд нэгтгэн авч үздэг боловч төсөвт тусгахдаа төслийн нийт өртгийг бус, зөвхөн төрөөс хүлээх санхүүгийн үүрэг (availability payment, хамтын санхүүжилт, баталгаа)-ийг тусган, дунд хугацааны төсвийн хүрээ болон төсвийн эрсдэлийн тайлангаар дамжуулан хянадаг байна.*

# ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БОДЛОГЫН АРГА ХЭМЖЭЭ-2026

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР



"Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай" анхдагч хуулийн төслийг батлуулах



Гадаад зээл, тусламжийн төслүүдийг хэрэгжүүлэх "нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн тогтолцоо"-нд бүрэн шилжүүлэх




Их өгөгдөл ашиглан, хиймэл оюун ухаан нэвтрүүлэх ажлыг эрчимжүүлж хөрөнгө оруулалтыг төлөвлөх



Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хуулийн хэрэгжилтийг сайжруулж, **төсвийн ачааллыг бууруулах**



Бүрэн дуусаагүй, орхигдсон барилга байгууламжуудыг ашиглалтад оруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх

# ОЛОН УЛСЫН ЖИШЭЭ: ТХХТ БА БОЛОВСРОЛ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

**ӨМНӨД СОЛОНГОС**

- 2005 оноос эхлэн сургуулийн барилгыг барих-арчлах-шилжүүлэх хэлбэрээр хэрэгжүүлж байгаа
- Сурагч, багш, бусад ажилчдын санал асуулгаар шууд төсвийн хөрөнгө оруулалтаас **илүү таатай** байдаг

**ГЕРМАН**

- Уламжлалт аргатай харьцуулахад барилга угсралтын зардал **12-31%**-иар бага
- Барилга угсралтын хугацаа **30%**-иар бага
- Засварын зардал **50%**-иар илүү боловч эвдрэл гэмтэл **38%**-иар бага
- Франкфуртын ТХХТ-ийн сургуулийн хувьд нийт зардал нь уламжлалт аргаас **15%**-иар бага

✓ Засвар, арчлалт болон төсвийн баталгаат байдал

✓ Гүйцэтгэлийн хяналт/гол хэмжүүр *(сургуулийн барилгын норм, дүрэм, засвар, арчлалтын гүйцэтгэлийн чанар, сурагчийн дүнгийн өөрчлөлт, санал асуулга, таслалт)*



# БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТАД ТХХТ-Г НЭМЭГДҮҮЛЭХ

*/тэрбум төгрөг/*

| | **УЛСЫН** ТӨСӨВ | **ГАДААД** ЗЭЭЛ, ТУСЛАМЖ | **ОРОН НУТГИЙН** ТӨСӨВ | **ТАТВАРЫН** 1%-ИЙН ХӨНГӨЛӨЛТ | **ТХХТ** | **НИЙТ 1,353.0** |
|---|---|---|---|---|---|---|
| | **506.8** | **588.4** | **257.8** | **...** | **...** | |
| Сургууль | 86 | 27 | 43 | 2025 онд **5 бага сургууль** ашиглалтад орсон | ... | **156** сургууль |
| Цэцэрлэг | 66 | 18 | 30 | | - | **114** цэцэрлэг |
| Дотуур байр | 35 | - | - | | - | **35** дотуур байр |
| Спорт заал | 16 | 1 | 3 | | - | **20** спорт заал |
| Тоног төхөөрөмж */тэрбум төгрөг/* | 74.6 | 14.6 | 3.0 | | ... | **92.2** |

# Агуулга

ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН УДИРДЛАГА

**ТӨР, ХУВИЙН ХЭВШЛИЙН ТҮНШЛЭЛ**

ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЯВЦАД ҮҮСЭЖ БУЙ АСУУДАЛ, ШИЙДЭЛ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

## Infrascope индекс, эдийн засаг (economist) сэтгүүл

*Infrascope индекс нь улс орнуудын дэд бүтцийн гол салбарууд болох тээвэр, эрчим хүч, ус хангамж, ариун цэвэр, хатуу хог хаягдлын менежмент, нийгмийн дэд бүтцийн чиглэлд төр, хувийн хэвшлийн түншлэлийг (ТХХТ) тогтвортой, үр ашигтай хэрэгжүүлэх чадавхыг үнэлэх харьцуулсан судалгаа*

Уг индекс нь төр, хувийн хэвшлийн түншлэлийн бэлэн байдал, чадавхыг дараах таван бүрэлдэхүүн хэсэгт ангилан үнэлдэг:

- Эрх зүйн орчин (хууль, журам)
- Институтийн тогтолцоо
- Хэрэгжилтийн бэлэн байдал, туршлага
- Хөрөнгө оруулалт, бизнесийн орчин
- Дэд бүтцийн төслийн санхүүжилтийн эх үүсвэр, боломж

*Эх сурвалж: ECONOMIST IMPACT*

Тэмдэглэгээ (өнгө): Төлөвшсөн, Хөгжсөн, Хөгжиж буй, Эхний шатанд

| | Нийт | Эрх зүйн орчин | Институтийн тогтолцоо | Хэрэгжилтийн бэлэн байдал | Хөрөнгө оруулалт, бизнесийн орчин | Санхүүжилт |
|---|---|---|---|---|---|---|
| Монгол | **52** | 54 | 71 | 42 | 67 | 33 |
| Тайланд | **80** | 87 | 97 | 72 | 76 | 72 |
| Чили (2024) | **77** | 97 | 80 | 78 | 83 | 63 |
| Гүрж | **45** | 58 | 8 | 43 | 74 | 43 |
| Казахстан | **59** | 54 | 86 | 48 | 72 | 41 |

*Дэлхийн дундаж 57*

# ТӨР, ХУВИЙН ХЭВШЛИЙН ТҮНШЛЭЛ (ТХХТ)-ИЙН ЗОРИЛГО /ТХХТ тухай хууль, 1-р зүйл/

*"ТХХТ нь **нийтийн зориулалттай дэд бүтэц, нийтийн үйлчилгээ** зэргийг хувийн хэвшилтэй хамтарч хийх **удаан хугацааны гэрээ** бөгөөд хувийн хэвшил эрсдэл, менежментийн хариуцлага хүлээдэг, төлбөрийг **гүйцэтгэлтэй уялдуулан ТӨР** /Government Pay/ эсвэл **ХЭРЭГЛЭГЧ** /User Pay/ **төлдөг хэлбэр юм.**"*

- Эрсдэлийг хувийн салбарт тэнцвэртэй хуваарилах
- Төсвийн зардлыг урт хугацаанд хуваарилж бууруулах
- Инновац, технологи
- Хөрөнгийн ашиглалт чанарыг сайжруулах
- Засгийн газрын авах зээлийг бууруулах

*"Нийтийн зориулалттай дэд бүтэц" гэж нийтэд зориулсан төрийн үйлчилгээний барилга байгууламж, авто зам, төмөр зам, дүүжин зам, газрын дээр, доор байрлах замын байгууламж, бүх төрлийн инженерийн шугам сүлжээ, гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх энгийн болон инженерийн хийц, бүтээц бүхий байгууламжийг*

# ТӨР, ХУВИЙН ХЭВШЛИЙН ТҮНШЛЭЛИЙН ТӨРӨЛ /ТХХТ тухай хууль, 14-р зүйл/

**ХЭРЭГЛЭГЧ ТӨЛӨХ ТХХТ**
/USER PAY/




**Хэрэгжүүлж болох төслүүд:**
*Авто зам, гүүр, инженерийн шугам сүлжээ, эрчим хүчний бүтээн байгуулалт зэрэг дэд бүтцийн төслүүд*

**ТӨРӨӨС ТӨЛӨХ ТХХТ**
/GOVERNMENT PAY/




**Хэрэгжүүлж болох төслүүд:**
*Сургууль, цэцэрлэг, эмнэлгийн ашиглалт, засвар, нийтийн тээвэр зэрэг нийгмийн салбарын төслүүд*

**ХОЛИМОГ ХЭЛБЭР**




***Хэрэгжүүлж болох төслүүд**: Нийгмийн салбарын төслүүд, нийгмийн салбарын үйлчилгээ*

# ТӨР, ХУВИЙН ХЭВШЛИЙН ТҮНШЛЭЛИЙН ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА: САЛБАРУУД

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

### АГРОБИЗНЕС

Энэ салбарт ТХХТ нь хөгжил дэвшлийг илүү өргөн хүртээмжтэй болгох, эрсдэл нь хэт өндөр байх тохиолдолд хувийн хэвшлийн оролцоог хангах

### БОЛОВСРОЛ & ЭРҮҮЛ МЭНД

Боловсрол, ЭМ-ийн салбарын ТХХТ нь боловсролын дэд бүтэц, технологи, чанарыг дээшлүүлэх болон үйлчилгээг хүргэх зорилгоор бүхэлд нь эсвэл зарим хэсэгт нь байгуулсан ЗГ, хувийн хэвшил хоорондын урт хугацааны гэрээ.

### МЭДЭЭЛЭЛ ХАРИЛЦАА ХОЛБОО

Цахим засаглалын төслүүдийг ТХХТ-ээр хэрэгжүүлэх нь чадавхийг бэхжүүлэх, зардлыг хэмнэх боломжийг олгодог.

### ХОТЫН ЗАХИРГАА

Хог хаягдал, хотын тээвэр, усан хангамж, дулаан хангамж, тохижилт, гэрэлтүүлэг зэрэг төслүүдийг ТХХТ-ээр хэрэгжүүлэх нь мөн л үйлчилгээг сайжруулах, зардлыг бууруулах боломжийг олгодог.

### ЭРЧИМ ХҮЧ

ТХХТ гэрээ байгуулдаг гол салбаруудын нэг, эрчим хүчний салбарт ТХХТ-ээр төслүүдийг хэрэгжүүлснээр ЗГ-ын санхүүжилт болон менежментийн ачааллыг бууруулдаг.

### АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ

Нийтлэг хэрэгждэг салбар бөгөөд хамгийн их орлогыг бий болгодог, нөгөө талдаа ТХХТ-ийн гэрээ түлхүү хэрэгждэг салбар юм.

### ЗАМ ТЭЭВЭР

Олон улсад 1990 оноос хойш тээврийн 1600 гаруй ТХХТ төсөл хэрэгжсэн. Хөгжиж буй орнуудад 470 тэрбум $ хөрөнгө оруулалт

### УС БОЛОН ЭРҮҮЛ АХУЙ

Сүүлийн 10 жилийн хугацаанд хөгжиж буй зах зээл дэх хувийн оролцоог хамарсан 545 усны төсөл хэрэгжсэн байна.

# **ХУВИЙН ХЭВШИЛД БИЙ БОЛОХ ДАВУУ ТАЛ** (ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА)

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

### ТОГТВОРТОЙ ОРЛОГЫН ЭХ ҮҮСВЭР

- ✓ Урт хугацааны гэрээ (10-30 жил)
- ✓ Төрөөс төлбөрийн үүрэг хүлээх зохицуулалт

**Жишээ:** Их Британийн *"Building Schools for the Future"* хөтөлбөрийн хүрээнд баригдсан сургуулиудад хувийн хэвшилд 25–30 жилийн хугацаанд үйлчилгээний бэлэн байдлын төлбөрийг тогтмол олгосон

### ЭРСДЭЛИЙН ЗОХИСТОЙ ХУВААРИЛАЛТ

- ✓ Төслийн эрсдэлийг талуудын хооронд оновчтой хуваарилна
- ✓ Бодлого, зөвшөөрлийн эрсдэлийг төр хариуцна

**Жишээ:** Канадын *"Ontario Highway 407 (EAST Extension)"* төслийн хүрээнд барилга, ашиглалтын эрсдэлийг хувийн хэвшил, харин зөвшөөрөл, газар чөлөөлөлтийн эрсдэлийг төр хариуцсан

### ТӨРИЙН ДЭМЖЛЭГ, ОРОЛЦОО

- ✓ Газрын асуудал, дэд бүтцийн холболтыг төрөөс шийдвэрлэнэ
- ✓ Хамтын санхүүжилт, татаас, баталгааны дэмжлэг үзүүлнэ

**Жишээ:** Вьетнамын *"Dau Giay–Phan Thiet Expressway"* авто замын төсөлд төрөөс хамтын санхүүжилт олгож, төслийн санхүүгийн ачааллыг бууруулсан

### ЗАХ ЗЭЭЛИЙН ТОГТВОРТОЙ ОРЧИН

- ✓ Нийтийн үйлчилгээ, дэд бүтцийн салбарт тогтвортой эрэлт бүрдэнэ
- ✓ Томоохон хэмжээний төсөлд оролцох боломж нэмэгдэнэ

**Жишээ:** Австралийн *"Royal Adelaide Hospital PPP"* төсөл нь урт хугацаанд үйлчилгээ үзүүлэх тогтвортой зах зээлийг хувийн хэвшилд бүрдүүлсэн

### САНХҮҮЖИЛТИЙН ЭХ ҮҮСВЭР ТАТАХ БОЛОМЖ

- ✓ Төртэй байгуулсан гэрээ нь эрсдэлийг бууруулах
- ✓ Санхүүгийн байгууллага, хөрөнгө оруулагчийн итгэл

**Жишээ:** Чилийн *"Ruta 5 (Pan-American Highway Concession)"* төслийн хүрээнд концессын гэрээнд тулгуурлан олон улсын санхүүжилт амжилттай татсан

### ГҮЙЦЭТГЭЛД СУУРИЛСАН УРАМШУУЛЛЫН ТОГТОЛЦОО

- ✓ Үйлчилгээний чанар, гүйцэтгэлд суурилсан төлбөрийн механизм үйлчилгээ
- ✓ Үр ашигтай хэрэгжилт нь орлогын өсөлтийг дэмжинэ

**Жишээ:** Өмнөд Солонгосын *"Incheon International Airport Expressway"* төслийн хүрээнд гүйцэтгэлийн үзүүлэлтээс хамаарсан төлбөрийн зохицуулалт хэрэглэсэн

# ТХХТ-ИЙН ЭРХ ЗҮЙН ОРЧИН

ТӨР, ХУВИЙН ХЭВШЛИЙН ТҮНШЛЭЛИЙН ТУХАЙ

УИХ 2025.12.09-ний өдөр баталсан.

**Хуулийн зорилго:**

Нийтийн зориулалттай дэд бүтэц, төрийн үйлчилгээний салбарт төр, хувийн хэвшлийн түншлэлийн төслийг хэрэгжүүлэх, хувийн хэвшлийн оролцоо, хөрөнгө оруулалтыг дэмжих, төр, хувийн хэвшил эрсдэлийн оновчтой удирдлагад суурилан түншлэлийн гэрээний дагуу урт хугацаанд үр ашигтай хамтран ажиллах болон санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан эрх зүйн таатай орчныг бүрдүүлэх

Сангийн сайдын **2023** оны **А/267** дугаар тушаал

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төсөвт үзүүлэх нөлөөлөл, төсвийн эрсдэл тооцох загвар батлах тухай

Засгийн газрын **2024** оны **210** дугаар тогтоол

Орон нутгаас хэрэгжүүлэх ТХХТ-ийн төслийн үе шатыг зохицуулах

Засгийн газрын **2023** оны **404** дүгээр тогтоол

Засгийн газраас хэрэгжүүлэх ТХХТ-ийн төслийн үе шатыг зохицуулах

Засгийн газрын **2023** оны **474** дүгээр тогтоол

Түншлэлийн төслийг хэрэгжүүлэхэд төрөөс дэмжлэг үзүүлэх, засгийн газрын баталгаа гаргах журам

Засгийн газрын **2023** оны **475** дүгээр тогтоол

Түншлэлээр хэрэгжүүлэх төслийн бүрэн шинжилгээг хянах болон түншлэлийн гэрээ байгуулах, гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулахад зөвшөөрөл олгох журам

*ТХХТ-ийн тухай хуульд 4 удаагийн нэмэлт, өөрчлөлт орсон. /(1) 2023.06.16 өөрчлөлт оруулах тухай; (2) 2024.06.05 нэмэлт, өөрчлөлт оруулах тухай; (3) 2024.08.30 нэмэлт, өөрчлөлт оруулах тухай; (4) 2025.11.14 нэмэлт, өөрчлөлт оруулах тухай./*

# ТҮНШЛЭГЧ ТАЛУУДЫН ТОДОРХОЙЛОЛТ

## “Төрийн түншлэгч"

түншлэлийн гэрээг хэрэгжүүлэх тухайн салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон түншлэлийн гэрээнд заасны дагуу энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан бусад этгээдийг;

## “Хувийн хэвшлийн түншлэгч"

төрийн түншлэгчтэй түншлэлийн гэрээ байгуулж, энэ хуульд заасан түншлэлийн төслийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий Компанийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын тухай хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан гадаад, дотоодын хөрөнгө оруулалттай хуулийн этгээд болон хуулийн этгээдийн нэгдлийг;

# ТАЛУУДЫН ЭРХ ҮҮРЭГ, ОРОЛЦОО /ТХХТ хууль, 2-р бүлэг/

| | УИХ | ЗАСГИЙН ГАЗАР | ЭЗХЯ | САНГИЙН ЯАМ | САЛБАР ЯАМ | ТҮНШЛЭЛИЙН ТӨВ | ОРОН НУТАГ | АУДИТ |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| **ТӨЛӨВЛӨЛТ** | • түншлэлийн зорилт, арга хэмжээг хэлэлцэж, хамт батлах, | • түншлэлийг хэрэгжүүлэх нийтийн зориулалттай дэд бүтэц, төрийн үйлчилгээний салбар, чиглэлийг батлах<br>• түншлэлээр хэрэгжүүлэх төслийг батлах | • урьдчилсан үнэлгээг хянан баталгаажуулах<br>• урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт тусгах | • Төслийн төсвийн эрсдэлийг хянаж, санхүүжилтийн эх үүсвэр болон төсөвт үзүүлэх нөлөөлөлд дүгнэлт гаргах<br>• Төрийн дэмжлэг, өрийн баталгаа, төсвийн эрсдэл, өрийн нөлөөллийг тооцож дүгнэх | • түншлэлээр хэрэгжүүлэх төслийн санал гаргах<br>• урьдчилсан үнэлгээг түншлэлийн төвтэй хамтран хийх | • урьдчилсан үнэлгээг салбар яамтай хамтран хийх<br>• Төслийн урьдчилсан болон бүрэн шинжилгээ, техник-эдийн засгийн үндэслэл, эрсдэлийн үнэлгээг төрийн түншлэгч, мэргэжлийн зөвлөх, төслийн багтай хамтран боловсруулах | • Тухайн орон нутгийн түншлэлийн төслийн саналыг боловсруулж, ИТХ-аар хэлэлцүүлэх | |
| **ХЭРЭГЖИЛТ** | • түншлэлийн төслийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлан мэдээллийг нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлантай хамт хэлэлцэх, хэрэгжилтэд хяналт тавих, чиглэл өгөх | • Засгийн газрын баталгааны асуудлыг энэ хуульд заасны дагуу шийдвэрлэх,<br>• түншлэлийн гэрээ байгуулах эрх олгох | • хувийн хэвшлийн түншлэгчийг сонгон шалгаруулах болон түншлэлийн гэрээ байгуулах ажлыг зохион байгуулах<br>• түншлэлийн гэрээг төрийн түншлэгч талыг төлөөлж салбарын яамтай хамтран байгуулах | | түншлэлийн хууль тогтоомжийн хэрэгжилт, гэрээний биелэлтийг хангах, хэрэгжилтэд хяналт тавих | • Түншлэгч талуудад мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх | • тухайн орон нутагт түншлэлээр хэрэгжиж байгаа төслийн хэрэгжилтийг хангах<br>• түншлэгч талуудад дэмжлэг үзүүлэх, хамтарч ажиллах,<br>• төслийн хэрэгжилтэд хяналт тавих | • төсөл хөгжүүлэх Санд жил бүр аудит хийх түншлэлийн төслийн төлөвлөлт, хувийн хэвшлийн түншлэгчийн сонгон шалгаруулалт, түншлэлийн төслийн хэрэгжилт болон гэрээний биелэлтэд аудит хийх |

# ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ШААРДАГДАХ ХУГАЦАА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

## ТӨСЛИЙН ТӨЛӨВЛӨЛТ

30 хоног

**ТӨСЛИЙГ ТОДОРХОЙЛОХ**

Урьдчилсан үнэлгээ

6 сар

**ТӨСЛИЙН ШИНЖИЛГЭЭГ ХИЙХ**

Бүрэн шинжилгээ

14 хоног

**ШИЙДВЭРЛЭХ**

Төсвийн эрсдэлийн үнэлгээ

## ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ

30 хоног

**СОНГОН ШАЛГАРУУЛАХ**

Ил тод, нээлтэй байх зарчим

Хугацаа заагаагүй

**ГЭРЭЭ БАЙГУУЛАХ**

Хэлэлцээр хийх

Төслийн онцлогоос хамаарч

**ХЭРЭГЖҮҮЛЭХ**

Гэрээний удирдлага Хяналт

30 хүртэл жил

**ШИЛЖҮҮЛЭХ**

Гэрээг дуусгавар болгох

# ТӨРӨӨС ХУВИЙН ХЭВШЛИЙН ТҮНШЛЭГЧИД ҮЗҮҮЛЭХ ДЭМЖЛЭГ, БАТАЛГАА

## ЗАСГИЙН ГАЗРЫН БАТАЛГАА




- Түншлэлийн гэрээ болон түүнийг дагалдан байгуулагдсан гэрээ, тэдгээрийн гол нөхцөл зөрчигдөх нөхцөл үүссэн тохиолдолд түншлэлийн төсөлд төсвөөс санхүүжүүлэх үүргийн баталгаа

- Түншлэлийн төслийг хэрэгжүүлэх явцад бий болсон бараа, ажил, үйлчилгээг худалдан авах, олон нийтийн хэрэгцээнд ашиглах, хэрэглэх баталгаа

## ТӨРИЙН ДЭМЖЛЭГ



### ГАЗРЫН ЗӨВШӨӨРӨЛ

- Төсөл хэрэгжүүлэхэд шаардлагатай тохиолдолд бусдын өмчлөл, эзэмшил, ашиглалтад байгаа газрыг хуульд заасны дагуу нөхөх олговортойгоор солих, эргүүлэн авах, эсхүл худалдан авах
- Төрийн өмчийн газрыг тодорхой болзол, гэрээний дагуу хувийн хэвшлийн түншлэлд ашиглуулах




### ТАТВАРЫН ЧӨЛӨӨЛӨЛТ

- Холбогдох хууль тогтоомжид заасны дагуу татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх



### ЭРСДЭЛ ХУВААЛЦАХ

- Түншлэлийн гэрээнд заасныар төслийн санхүүжилтийн тодорхой хэсгийг төсвөөс санхүүжүүлэх

- Шаардлагатай тохиолдолд түншлэлийн зүйлийг даатгалд хамруулах



### БУСАД ДЭМЖЛЭГ

- өрийн үйлчилгээг үзүүлэх нөхцөлөөр хангах, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг ашиглах эрх олгох

- Түншлэлийн төслөөр бий болгохоос бусад төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай нийтийн зориулалттай дэд бүтэц, төрийн үйлчилгээгээр хангах

# БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУССАН ТӨСЛҮҮД

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

| Монгол улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл | Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр 2024-2028 | Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө 2026 |
|---|---|---|
| 4 төсөл | 52 төсөл | 12 төсөл |
| 2026-2030 онд санхүүжих дүн **4.3 их наяд ₮** | 2026 онд санхүүжих дүн **5.3 их наяд ₮** | 2026 онд санхүүжих дүн **4.4 их наяд ₮** |

Үүнээс **5 төсөл** Сангийн яамнаас зөвшөөрөл, санал, дүгнэлт авахаар хүсэлт **ирүүлсэн байна**

| | Төслийн нэр | Монгол улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл | Монгол улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл | Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө 2026 |
|---|---|---|---|---|
| 1 | Дулааны тавдугаар цахилгаан станц | ✓ | | |
| 2 | Улиастай-Мөрөн хүртэлх 261.65 км авто зам | | ✓ | |
| 3 | Байдрагийн усан цахилгаан станцын төсөл | | ✓ /гадаад зээл, тусламж/ | |
| 4 | Хог шатааж эрчим хүч үйлдвэрлэх 35 МВт цахилгаан станц | | ✓ | |
| 5 | Нийтийн тээврийн Улаанбаатар Трамвай (Хөнгөн галт тэрэг - LRT) | | ✓ | |

# Агуулга

ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН УДИРДЛАГА

ТХХТ ХЭРЭГЖИЛТ

**ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЯВЦАД ҮҮСЭЖ БУЙ АСУУДАЛ, ШИЙДЭЛ**

# ТХХТ-ИЙН ТӨСЛҮҮДИЙН ОДООГИЙН ЯВЦ:

| № | ТӨСЛИЙН НЭР | САЛБАР | НИЙТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ /тэрбум ₮/ | БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ /ЖИЛ/ | АШИГЛАЛТ /ЖИЛ/ | ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ | ТҮНШЛЭЛИЙН ТӨРӨЛ | ДҮГНЭЛТ, ЗӨВШӨӨРӨЛ ГАРСАН ЭСЭХ | ТӨСЛИЙН ҮЕ ШАТ | ТХХТ-ЭЭР ХЭРЭГЖҮҮЛЭХ ШИЙДВЭР ГАРАХ ХҮРТЭЛХ ХУГАЦАА |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Улиастай-Мөрөн хүртэлх 261.65 км авто зам | Авто зам | 593.4 | 2025 - 2028 | 23 жил | ЭЗХЯ | Барих-ашиглах-шилжүүлэх | Тийм | Сонгон шалгаруулалт | 1.5 жил |
| 2 | Байдрагийн усан цахилгаан станцын төсөл | Эрчим хүч | 184.9 | 2026 - 2030 | 25 жил | ЭЗХЯ | БОННҮ хийх-зураг төсөл боловсруулах, барих, ашиглах, шилжүүлэх | Тийм | ЗГ-аар батлуулах | 4 сар |
| 3 | Улаанбаатар хотын такси үйлчилгээг сайжруулах нь | Тээврийн үйлчилгээ | 77.0 | | | НЗДТГ | Тодорхойгүй | Дэмжээгүй | Сонгон шалгаруулалт | |
| 4 | Хүннү хотын өөрийн эх үүсвэрээс цэнэглэх 90 МВт батарей хуримтлуур | Эрчим хүч | 292.8 | 2026 - 2028 | 25 жил | НЗДТГ | Зураг төсөл боловсруулах, барих, ашиглах, шилжүүлэх | Нэмэлт мэдээлэл хүссэн | Сонгон шалгаруулалт | 7 сар |
| 5 | Нийтийн тээврийн Улаанбаатар Трамвай (Хөнгөн галт тэрэг - LRT) | Нийтийн тээвэр | 2,182.0 | 2026 - 2028 | 27 жил | НЗДТГ | Зураг төсөл боловсруулах, барих, ашиглах, шилжүүлэх | Дэмжээгүй | Сонгон шалгаруулалт | 3.5 сар |
| 6 | Хог шатааж эрчим хүч үйлдвэрлэх 35 МВт цахилгаан станц | Хог хаягдлын менежмент | 697.4 | 2026 - 2028 | 28 жил | НЗДТГ | Зураг төсөл боловсруулах, барих, ашиглах, шилжүүлэх, Санхүүжилт, Удирдлагыг хэрэгжүүлэх | Тийм | Сонгон шалгаруулалт | 3.5 сар |
| 7 | Дулааны тавдугаар цахилгаан станц (ТЭЦ 5) | Эрчим хүч, дулаан хангамж | 2,305.0 | 2026 - 2028 | 27 жил | НЗДТГ | Зураг төсөл боловсруулах, барих, ашиглах, шилжүүлэх | Тийм | Хэрэгжилт | 6 сар |
| 8 | Хөвсгөл аймгийн Рэнчинлхүмбэ сумын төвийн төвлөрсөн халаалт, цэвэр усны шугам сүлжээ, зуухны барилга | Инженерийн дэд бүтэц | | | | Орон нутаг | Тодорхойгүй | - | Төслийг тодорхойлох | |
| 9 | Тайван зогсоол цогцолборын ачаа тээврийн терминал төсөл | Ложистик | 102.0 | | 15 жил | ЭЗХЯ | Түрээслэх болон түрээслүүлж төрийн үйлчилгээг үзүүлэх | - | Бүрэн шинжилгээ | |

# ТУХАЙЛБАЛ: ДУЛААНЫ 5-Р ЦАХИЛГААН СТАНЦ

**ХЭРЭГЖИХ ХУГАЦАА:**
**2026 – 2028**

**ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ:**
**658.56**
сая ам.доллар

**ЭХ ҮҮСВЭР:**
**ТХХТ - DBFOM**
**(Нийслэл 20%, хувийн хэвшил 80%)**

**ХУВИЙН ТҮНШЛЭГЧ АШИГЛАХ:**
**25 жил**




Цахилгааны хүчин чадал: **300 МВт**
Дулааны хүчин чадал: **340 Гкал/ц**
Шугамын урт: **130 хос метр**
Авто зам: **127.4 км**
Төлөвлөсөн хүн ам: **150,000**

- Шинээр баригдах ДЦС - 5
- Дулааны шугам, сүлжээ

| ТӨСӨЛ САНААЧЛАХ | ТӨСЛИЙН ЖАГСААЛТ БАТЛАХ | УРЬДЧИЛСАН ҮНЭЛГЭЭ | БҮРЭН ШИНЖИЛГЭЭ | САНГИЙН ЯАМНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ | ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ ШИЙДВЭР | СОНГОН ШАЛГАРУУЛАЛТ | ГЭРЭЭ БАЙГУУЛАХ | ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ○ |
| НЗДТГ | НИТХ "ТХХТ-ээр нийслэлд хэрэгжүүлэх төслийн жагсаалт батлах тухай" тогтоолд төслийг тусган баталсан. 2025.01.27 | Түншлэлээр хэрэгжүүлэх боломжтой гэж дүгнэсэн. 2025.04.17 | Түншлэлээр хэрэгжүүлэхэд тохиромжтой гэж тодорхойлсон. | Бүрэн шинжилгээний тайлан, дүгнэлтийг судлан үзэж санал, зөвлөмжийг хүргүүлсэн. 2025.05.16 | НИТХ-ын 25/84 тогтоолоор төслийн ТХХТ-ээр хэрэгжүүлэхийг зөвшөөрсөн. 2025.05.26 | Хувийн хэвшлийн түншлэгч сонгон шалгаруулалт зарласан. 2025.05.26 | НИТХ-ын хуралдаанаар гэрээ байгуулах эрхийг НЗД-д олгож, гэрээ байгуулсан. 2025.10.24 | |

# ТХХТ-ИЙН МЕНЕЖМЕНТИЙН ЧАДАВХ БЭХЖҮҮЛЭХ ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БАЙНА.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

JICA

PPPrism
PPP Risk & Investment Strategy Management in Mongolia

Японы ЖАЙКА байгууллагатай хамтран хэрэгжүүлж буй **"Төсвийн зохистой удирдлагад чиглэсэн төр, хувийн хэвшлийн түншлэлийн менежментийн чадавх бэхжүүлэх"** төсөл

## Төслийн зорилго

1. Улсын хөрөнгө оруулалтын удирдлагын үе шат бүрд түншлэлийн төслийн эрсдэлийг тодорхойлж, үнэлэх үйл явц тодорхой болно.
2. Түншлэлийн төслийн болзошгүй өр төлбөр зэрэг төсвийн эрсдэлийн шинжилгээний чадавх бэхжиж, төсөв, санхүүгийн удирдлагад тусгах үйл явц тодорхой болж, бэхжинэ.
3. Түншлэлийн төслийн оновчтой удирдлага, хувийн хэвшлийн оролцоог дэмжихэд чиглэсэн ТХХТТ-ийн үйл ажиллагаа бэхжинэ.

## 2026 оны ажлын төлөвлөгөө

1. Төлөвлөлт, үнэлгээ, сонгон шалгаруулалтын **Стратегийн удирдамж** боловсруулна /ЭЗХЯ/
2. **Түншлэлийн төслийн төсвийн эрсдэлийн удирдлагын гарын авлага** боловсруулна /СЯ/
3. **ТХХТ-ийн үйл ажиллагааны удирдамж** боловсруулна /ТХХТ-ийн төв/

# ТХХТ-ЫН ТӨСЛҮҮД ТХОУЦС /PIMIS/-Т НЭВТЭРЛЭЭ

- Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай **хууль, холбогдох журмууд**
- Сангийн яаманд зөвшөөрөл, санал, дүгнэлт авахаар ирүүлсэн **төсөл, арга хэмжээний мэдээлэл, явц**
- **Бодлогын баримт бичигт туссан** төр, хувийн хэвшлийн түншлэлийн төслүүд
- Төр, хувийн хэвшлийн түншлэлтэй холбоотой **мэдээ, мэдээлэл**

**www.publicinvestment.gov.mn/ppp**



# АНХААРАХ АСУУДАЛ БА ШИЙДЭЛ

## Тулгамдаж буй асуудал

1. **ТХХТ-д хамаарахгүй:** Нийтийн зориулалттай дэд бүтэц, төрийн үйлчилгээний салбарт хамаарахад эргэлзээтэй
2. **Мөнгөний үнэ цэнэ болон хувилбарын шинжилгээ:** Хэрэгжүүлэх/санхүүжүүлэх, техникийн шийдлийн, байршлын гэх мэт хувилбаруудын харьцуулалт цөөн, хэрхэн сонгосон үндэслэл дутмаг
3. **Санхүүгийн хэт өөдрөг тооцоолол:** Магадалшгүй ажил, зээлийн хүү зэрэг зардлыг багаар тооцох, борлуулалтын орлогыг хэт өөдрөгөөр тооцох
4. **ЗГ баталгаа, дэмжлэгийн хэлбэр тодорхой бус**
5. **Мэдээлэл дутуу, төсвийн нөлөө, эрсдэл бүрэн тооцоогүй:** эрчим хүчний төслүүдэд цахилгааны тарифын алдагдал, төсвийн нөлөө, эрсдэл, зарим төслүүдэд зардлыг хэт тойм тооцсон

## ШИЙДЭЛ

1. Хувийн хэвшлийн түншлэгчид чиглэсэн мэдээлэл, гарын авлага, жишиг төслүүдийг тогтмол түгээж, ТХХТ-ийн хамрах хүрээг ойлгомжтой болгох;
2. ТХХТ-ийг хэрэгжүүлэхэд төрийн түншлэгч талын чадавхыг бэхжүүлж, мэргэшсэн баг, аргачлал, сургалтаар тогтвортой дэмжих
3. ТХХТ төслийн урьдчилсан үнэлгээний шатанд зах зээлийн тандалт (market sounding)-ын механизмыг нэвтрүүлж, төслийн шийдлийг бодит эрэлт, зах зээлийн нөхцөлд нийцүүлэх.
4. ТХХТ төслийн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлж, төсөв, тариф, эрсдэлийн тооцооллыг нэг стандартын дагуу боловсруулах чадавхыг нэмэгдүүлэх.

МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР

САНГИЙН ЯАМ

# ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН УДИРДЛАГЫН ТУХАЙ

анхдагч хуулийн төсөл

# ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

## ХУУЛЬ ЗҮЙН

1. ЗГҮАХ 2024-2048: **“Төсвийн хөрөнгө оруулалтыг их өгөгдөлд суурилан төлөвлөх”**
2. **Засгийн тогтоол, албан даалгавар:** ТХО хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох хуулийн төсөл боловсруулж, УИХ-д өргөн мэдүүлэх
3. **Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүгнэлт, зөвлөмж** /2024 он/
4. **Олон Улсын Валютын сангаас өгсөн дүгнэлт, зөвлөмж** /2023 он/

## ПРАКТИК

1. Төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрүүдийн **нэгдсэн удирдлага, зохицуулалт сул**
2. 2016 – 2025 онд 2,874 төсөл батлагдсан боловч **43%-д нь нэмэлт санхүүжилт үүссэн.** 3 төсөл тутмын **1 нь хугацаа сунгадаг**
3. Хөрөнгө оруулалтын бэлтгэл ажил **болох зураг төсөл, төсөв, ТЭЗҮ гэсэн нэгдсэн зохицуулалт байхгүй, хариуцлага, хяналт сул**
4. Хөрөнгө оруулалтын төслүүдийн **ангилал, төрөл тодорхойгүйгээс хэрэгжилтэд асуудал бий болдог**
5. **Хөрөнгө оруулалтын удирдлагыг олон улсын жишигт нийцүүлэх, их өгөгдөл, хиймэл оюунд суурилсан** удирдлага болон ил тод байдал, **үр ашиг, үр нөлөөг дээшлүүлэх шаардлагатай**

# ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

- 2026 онд улсын төсөвт батлагдсан төслүүдийн хувьд **70.0 сая ₮ - 320.0 тэрбум ₮** хооронд байна.
- Гадаад зээл, тусламжаар хэрэгжиж буй төслүүдийн хувьд **23 тэрбум ₮ - 6.2 их наяд ₮** хооронд байна.




## 1 Бүх төсөлд **ижил шалгуур** байна

*Шалгуур үзүүлэлтийн дагуу*
***5 түвшинд ангилна***

I. Хөрөнгө оруулалтын хэмжээ
II. Хэрэгжих хугацаа
III. Цар хүрээ
IV. Оролцогчид
V. Үр ашиг, үр нөлөө, ач холбогдол
VI. Эрсдэл

## 2 ТЭЗҮ, зураг төсөв, төслийн тухай **нэгдсэн ойлголтгүй**

***ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬ:***
*"Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана."*

x Барилгын тухай хууль, журам, дүрэм
x Эрчим хүчний тухай хууль, журам, дүрэм
x Авто замын тухай хууль, журам, дүрэм

## 3 Техник, технологи, зохиогчийн хяналт, магадалшгүй ажил, нормчлолын сангийн **зардлыг бүх төсөлд адил % хэмжээгээр тогтоож байна.**

✓ 2016 – 2024 онд улсын төсвөөр **14.4 их наяд ₮** хөрөнгө оруулалт хийв.

✓ Үүний **5.5%** буюу **0.8 их наяд** төгрөгийг дээрх зардалд зарцуулав.

## 4 2023-2024 онд 964 тэрбум ₮-н **нэмэлт санхүүжилт** олгосон

✓ 2023 онд "Материалын үнийн өсөлт" **303.4 т.б ₮**

✓ 2024 онд "Төсөвт өртгийн нэмэгдэл" **606.6 т.б ₮**

- 2025 онд "Цалингийн зардал" – **2009 оны индексийг 2019 оны индексээр тооцохоор шийдвэрлэв**

✓ 2026 онд "Төсөвт өртгийн нэмэгдэл" **170.5 т.б ₮**

# ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

## ХУУЛЬ ЗҮЙН

1. ЗГҮАХ 2024-2048: **“Төсвийн хөрөнгө оруулалтыг их өгөгдөлд суурилан төлөвлөх”**
2. **Засгийн тогтоол, албан даалгавар:** ТХО хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох хуулийн төсөл боловсруулж, УИХ-д өргөн мэдүүлэх
3. **Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүгнэлт, зөвлөмж** /2024 он/
4. **Олон Улсын Валютын сангаас өгсөн дүгнэлт, зөвлөмж** /2023 он/

## ПРАКТИК

1. Төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрүүдийн **нэгдсэн удирдлага, зохицуулалт сул**
2. 2016 – 2025 онд 2,874 төсөл батлагдсан боловч **43%-д нь нэмэлт санхүүжилт үүссэн.** 3 төсөл тутмын **1 нь хугацаа сунгадаг**
3. Хөрөнгө оруулалтын бэлтгэл ажил **болох зураг төсөл, төсөв, ТЭЗҮ гэсэн нэгдсэн зохицуулалт байхгүй, хариуцлага, хяналт сул**
4. Хөрөнгө оруулалтын төслүүдийн **ангилал, төрөл тодорхойгүйгээс хэрэгжилтэд асуудал бий болдог**
5. **Хөрөнгө оруулалтын удирдлагыг олон улсын жишигт нийцүүлэх, их өгөгдөл, хиймэл оюунд суурилсан** удирдлага болон ил тод байдал, **үр ашиг, үр нөлөөг дээшлүүлэх шаардлагатай**

# ХУУЛИЙН ТӨСЛИЙН ЗОРИЛГО, ҮЙЛЧЛЭХ ХҮРЭЭ, БҮТЭЦ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

## Зорилго

**Хөгжлийн бодлогын зорилго, зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд** нийгэм, эдийн засгийн дэд бүтцийг бүрдүүлэхэд төсвийн хөрөнгө оруулалтын төслийн төлөвлөлт, хэрэгжилт, санхүүжилт, хяналт, тайлагналт, хөрөнгийн удирдлага, ашиглалтыг ил тод, үр ашигтай хэрэгжүүлэхтэй холбогдуулан **төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын эрх зүйн нэгдмэл орчныг бүрдүүлэхэд оршино.**

## Үйлчлэх хүрээ

- Улсын төсөв
- Гадаадын зээл
- Орон нутгийн төсөв
- Орон нутгийн хөгжлийн сан

**Зохицуулах харилцаа:** Төслийг эрэлт хэрэгцээнд үндэслэн үнэлэх, эрэмбэлэх, төлөвлөх, хэрэгжүүлэх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах, хөрөнгийн удирдлага, ашиглалтын бүрэн үйл ажиллагаа

**Тусгайлан зохицуулах:** худалдан авах ажиллагааг холбогдох хуулиар, төрийн нууцтай холбоотой асуудлыг тусгайлан хуулиар зохицуулна

## Бүтэц

- ✓ **8** бүлэг
- ✓ **61** зүйл
- ✓ **313** хэсэг
- ✓ **279** заалт
- ✓ **3** хүснэгт
- ✓ **7** заалтын тайлбар

# ХУУЛИЙН ТӨСЛИЙН БҮТЭЦ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

## I НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1. Хуулийн зорилго
2. Хууль тогтоомж
3. Хуулийн үйлчлэх хүрээ
4. Хуулийн нэр томьёоны тодорхойлолт
5. ТХО-ын удирдлагын зарчим
6. ТХО-ын үе шат
7. ТХО-аар хэрэгжүүлэх төслийн ангилал, төрөл
8. ТХО-д хориглох зүйл

## II ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН УДИРДЛАГЫН ТАЛААРХ ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН БҮРЭН ЭРХ, ЧИГ ҮҮРЭГ

1. УИХ-ын бүрэн эрх
2. Засгийн газрын бүрэн эрх
3. Эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх
4. Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний бүрэн эрх
5. Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх
6. Төсвийн ерөнхийлөн захирагчийн бүрэн эрх
7. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны Зөвлөлийн бүрэн эрх
8. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны Захирагчийн бүрэн эрх
9. Захиалагчийн чиг үүрэг

## III ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨЛТ, ТӨСЛИЙН ҮНЭЛГЭЭ, ТАВИГДАХ ШААРДЛАГА

1. ТХО-ын бодлого, тэргүүлэх салбар
2. ТХО-ын эх үүсвэр, зориулалт
3. ТХО-ын төсөлд тавигдах шаардлага
4. Төслийн төлөвлөлт, бэлтгэл ажлыг хангах
5. Гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийг төлөвлөх, үнэлэх, шийдвэрлэх
6. Техник, эдийн засгийн үндэслэл
7. Төслийн техник, эдийн засгийн үндэслэлийн тайлан
8. Төслийн нийгмийн ач холбогдол, эдийн засгийн үр ашиг
9. Төслийг үнэлж, эрэмбэлэх
10. Төслийг улс, орон нутгийн төсөвт тусгах

## IV ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ, САНХҮҮЖИЛТ, ХЯНАЛТ, ТАЙЛАГНАЛТ

1. ТХО-ын төслийн хэрэгжилт
2. Эрх шилжүүлэх, багц хуваарилах
3. Төслийн гэрээний удирдлага
4. Төслийн гүйцэтгэлийн санхүүжилт
5. Төслийн зардлын санхүүжилт
6. Их засвар болон тоног төхөөрөмжийн төслийн санхүүжилт
7. Гадаад зээл, тусламжийн удирдлага, зохицуулалт
8. Төслийн санхүүжих дүн хийх хөрөнгийн зохицуулалт
9. Төсөвт өртгийн өөрчлөлт
10. Төслийн хэрэгжилтэд хяналт тавих
11. Тайлагналт, үр дүн
12. Гадаад зээл, тусламжийн төслийн хяналт-шинжилгээ, үнэлгээ болон тайлагналт

## V ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН УДИРДЛАГЫН ИЛ ТОД, НЭЭЛТТЭЙ БАЙДАЛ, ЦАХИМ СИСТЕМИЙН УДИРДЛАГА

1. Мэдээллийн сан, ил тод, нээлттэй байдал
2. Олон нийтийн оролцоо
3. Цахим системийн удирдлага, зохион байгуулалт
4. Гадаад зээл, тусламжийн мэдээллийн ил тод байдал, цахим систем

## VI ХӨРӨНГИЙН УДИРДЛАГА, АШИГЛАЛТ, ТҮҮНИЙ ҮР ӨГӨӨЖ

1. ТХО-ын хөрөнгийн удирдлага
2. Хөрөнгийн бүртгэл, өмчлөл
3. Төрийн болон орон нутгийн өмчийн мэдээллийн сан
4. Хөрөнгийн ашиглалт, сайжруулалт
5. Түүхэн дурсгалт барилга байгууламж, архитектурын дурсгалыг хамгаалах, хадгалах, сэргээн засварлах
6. ТХО-ын хөрөнгийн үр өгөөж

## VII ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН УДИРДЛАГЫН САН

1. ТХО-ын удирдлагын сан
2. ТХО-ын удирдлагын сангийн эх үүсвэр
3. ТХО-ын удирдлагын сангийн хөрөнгийн зориулалт, зарцуулалт
4. ТХО-ын удирдлагын сангийн ил тод байдал, тайлагналт
5. Төслийн гүйцэтгэгчийг үнэлэх
6. Төслийн гүйцэтгэгчийн дэмжлэг болон хариуцлага
7. Давагдашгүй хүчин зүйл болон гамшгийн үеийн зохицуулалт

## VIII БУСАД

1. Маргаан шийдвэрлэх
2. Хохирол, гэм хор нөхөн төлүүлэх
3. Хариуцлага хүлээлгэх үндэслэл
4. Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага
5. Хууль хүчин төгөлдөр болох

# ОНЦЛОХ ЗОХИЦУУЛАЛТ: ТӨСЛИЙН АНГИЛАЛ

*Хуулийн төслийн **1 дүгээр бүлэг, 7 дугаар зүйл***

**ТЭЗҮ-г төслийн онцлогоос хамааруулан хийж болно*

| АНГИЛАЛ | ТӨСӨВТ ӨРТӨГ /төгрөг/ | ХЭРЭГЖИХ ХУГАЦАА | ЭХ ҮҮСВЭР | БЭЛТГЭЛ АЖИЛ, ТӨСӨВТ ТУСГАХ |
|---|---|---|---|---|
| **I түвшин буюу жижиг** | **5.0 тэрбум** хүртэл | 2 хүртэлх жил | ОН, ОНХС, ГТ | Зураг төсөл, төсөв * |
| **II түвшин буюу дунд** | **5.0-20.0 тэрбум** хүртэл | 3 хүртэлх жил | УТ, ГЗ, ОН, ОНХС, ГТ | Зураг төсөл, төсөв * |
| **III түвшин буюу том** | **20.0-100.0 тэрбум** хүртэл | 4 хүртэлх жил | УТ, ГЗ, ГТ, ОН | ТЭЗҮ* , зураг төсөл, төсөв |
| **IV түвшин буюу хөгжлийн** | **100.0-350.0 тэрбум** хүртэл | 5 хүртэлх жил | УТ, ГЗ, ГТ, ОН | ТЭЗҮ * |
| **V түвшин буюу мега** | **350.0 тэрбумаас** дээш | 5 хүртэлх, түүнээс дээш жил | УТ, ГЗ, ГТ, ОН | ТЭЗҮ * |

**Зөрүү үүсвэл:** Төсөвт өртөг болон хугацаа зөрсөн тохиолдолд төсөвт өртгийг суурь үзүүлэлтэд тооцно

**Мега төслийн тодорхойлолт:** Улсын эдийн засаг, нийгмийн хөгжилд стратегийн ач холбогдол бүхий, их хэмжээний хөрөнгө оруулалт шаардсан иж бүрэн төлөвлөлттэй V ангиллын төсөл

# ОНЦЛОХ ЗОХИЦУУЛАЛТ: ЗАРЧИМ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

**НИЙЦЭЛ**
Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцсэн байх

**ҮР АШИГ**
Шинжилгээнд үндэслэсэн, нийгмийн ач холбогдол, эдийн засгийн өгөөжтэй байх

**ЭРЭМБЭ**
Шилжих буюу он дамжин хэрэгжүүлж байгаа төслийг төсвийн төсөлд эхэнд тусгах

**ИЛ ТОД БАЙДАЛ**
Олон нийтийн оролцоог хангаж, мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг бүрдүүлэх

**ХЯНАЛТ**
Хөндлөнгийн аудит, үнэлгээний тогтолцоог бүрдүүлж, захиалагч, зохиогчийн хяналтыг тасралтгүй хэрэгжүүлэх

**ХАРИУЦЛАГА**
Төсвийн сахилга бат, мэргэжлийн ёс зүйг баримтлан, хууль ёсны дагуу, ашиг сонирхлын зөрчилгүй, авлигаас ангид, хараат бус, бие даан гүйцэтгэж, санхүүгийн хариуцлагыг чанд баримтлах

**ЦАХИМ УДИРДЛАГА**
Их өгөгдөл, хиймэл оюун ухаан, дижитал дэд бүтцэд тулгуурлан цахим системээр хэрэгжүүлэх

**ОНОВЧТОЙ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ**
**Хувийн хэвшил хэрэгжүүлэх боломжтой төслийг төсвөөр санхүүжүүлэхгүй байх**

**ҮР ӨГӨӨЖИЙГ ХАДГАЛАХ**
Хөрөнгийг төрийн болон орон нутгийн өмчид бүртгэж, ашиглалт, сайжруулалтыг тогтмол хийх

**НОГООН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ**
Байгаль орчинд ээлтэй, ногоон хөгжлийг дэмжсэн, хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах

# БАЯРЛАЛАА.

Монгол Улсын Сангийн яам
**www.mof.gov.mn**

Сангийн яам, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газар
**5126 – 7207** /Улсын төсөв, ТХХТ/**, 5126 – 3442** /Гадаад зээл, тусламж/

Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем
**www.publicinvestment.gov.mn**

PIMIS систем
**7700 - 1313**